

ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ



ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК



ЭН ЭС И КОНСАЛТИНГ ХХК

**“ТАВАНТОЛГОЙТӨМӨР ЗАМ”  
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ**

**болон**

**““ЭН ЭС И КОНСАЛТИНГ” ХХК”  
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ**

**нарын хооронд байгуулсан**

**“БОГДХАН ТӨМӨР ЗАМ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ  
ОРЧНЫ НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ  
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ**

**Гэрээний дугаар: АГГ- 01/33/18**

**2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр  
Улаанбаатар хот**

**“БОГДХАН ТӨМӨР ЗАМ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН  
ҮНЭЛГЭЭ, БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ  
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**

2022 оны 6 дугаар сарын  
03-ны өдөр

№ 115-09/33/18

Улаанбаатар хот

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: “ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК  
ТӨСЛИЙН НЭР: “БОГДХАН ТӨМӨР ЗАМ”

### **НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1. Энэхүү гэрээг нэг талаас “Тавантолгой төмөр зам” ХХК (цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Н.Удаанжаргал, нөгөө талаас “Эн Эс И Консалтинг” ХХК (цаашид “Гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Пүрэвжамц нар дараах ажлыг хийж гүйцэтгэхээр харилцан тохиролцож гэрээ байгуулав.
- 1.2 Уг гэрээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, заавар, журмаар зохицуулагдах ба дараах ажил үүргийг гүйцэтгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна. Үүнд:
  - a. Гүйцэтгэх ажил:
    1. Улаанбаатар хотын СХД-ийн 21, 32 дугаар хороо, Төв аймгийн Аргалант, Алтанбулаг, Баян, Сэргэлэн сумдын нутагт хэрэгжих “Богдхан төмөр зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хийх, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар ерөний үнэлгээний дүгнэлт гаргуулах;
    2. “Богдхан төмөр зам” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах;
  - b. Гүйцэтгэх хугацаа:
 

Гэрээт ажлыг гэрээ батлагдсан өдрөөс хойш буюу 2 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ.
  - c. Гэрээний үнэ:
 

Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт үнэ 400,000,000 (дөрвөн зуун сая) төгрөг байх ба уг үнэд ААНОАТ болон холбогдох татвар хураамж, шимтгэл бүгд багтсан болно.
  - d. Төлбөр төлөх нөхцөл:
    1. Гэрээ хүчин төгөлдөр болж, нэхэмжлэхийг Захиалагчид хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор гэрээний үнийн дүнгийн 30% буюу 120,000,000 (нэг зуун хорин сая) төгрөгийн урьдчилгаа,
    2. Явц дундын гүйцэтгэл буюу байгаль очрны төлөв байдлын үнэлгээг БОАЖЯ-нд хянуулж, ерөнхий

үнэлгээний дүгнэлт гаргуулсны дараа 40% буюу  
160,000,000 (нэг зуун жаран сая) төгрүүг,

2. Үлдэгдэл 30% буюу 120,000,000 (нэг зуун хорин сая)  
төгрүүгийг БОННҮ-ний тайланг боловсруулан БОАЖЯ-  
аар батлуулсаны дараа Захиалагч Гүйцэтгэгчээс  
ирүүлсэн нэхэмжлэхэд үндэслэн тус тус төлнө.

3. Гүйцэтгэгч “Эн Эс И Консалтинг” ХХК-ийн Голомт  
банкны данс: 3675103004 (MNT)

- 1.3 Гэрээгээр гүйцэтгэсэн ажил нь Захиалагчийн өмч бөгөөд Гүйцэтгэгч  
Захиалагч хоёроос бусад гуравдагч этгээдэд нууц байна.

### **ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 2.1 Ажлын явц, төсөв, төлөвлөгөөтэй танилцаж өөрийн санал, хүсэлтийг  
тусгуулах эрхтэй.
- 2.2 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг холбогдох хууль тогтоомж, зохих норм, дүрэм,  
журмын дагуу хийж гүйцэтгээгүй, хугацаа алдсан зэргээр ноцтой алдаа,  
дутагдал (эдгээрээр хязгаарлагдахгүй) гаргасан тохиолдолд Захиалагч нь  
гэрээт ажлыг сайжруулах талаар шаардлага тавих эрхтэй.
- 2.3 Захиалагч нь БОННҮ-ний тайлантай ажлын 3 хоногийн дотор танилцаж  
холбогдох саналаа өгнө.

### **ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг холбогдох хууль тогтоомж, зохих норм, дүрэм,  
журам, заавар, стандартын дагуу хугацаанд нь үнэн зөв алдаа мадаггүй хийж  
гүйцэтгэх үүрэгтэй.
- 3.2 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг хийж гүйцэтгэх бүхий л зохион байгуулалтын арга  
хэмжээг хариуцан ажиллана.
- 3.3 Захиалагчаас хүлээн авсан баримт, материал (үүнд, цахим өгөгдөл мөн  
хамаарна) зөвхөн Гэрээгээр гүйцэтгэх ажилд зориулан ашиглахаас бусдаар  
ашиглаж үл болно. Эдгээр баримт материалыг ажил дууссаны дараа  
Захиалагчид бүрэн хүлээлгэж өгөх үүрэгтэй.
- 3.4 Гүйцэтгэгч нь холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр ажлын  
тайлангуудад нэмэлт өөрчлөлт хийх шаардлага гарвал түүнийг шийдвэр  
гарсан өдрөөс хойш нэг сарын дотор багтаан өөрийн зардлаар хийж  
гүйцэтгэнэ.
- 3.5 Гүйцэтгэгч нь Захиалагч талд БОАЖЯ-аар батлуулсан БОННҮ-ний тайлан эх  
хувь 1, тухайн жилийн БОМТ 1 хувь, тайлангийн цахим хэлбэрийг CD-нд  
хуулж тус тус хүлээлгэж өгнө.

### **ДӨРӨВ. ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА**

- 4.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүрэг, тус тусын бизнесийн үйл ажиллагааг  
харилцан хүндэтгэнэ.

- 4.2. Үнэлгээн дэх олон нийтийн оролцоог хангахдаа БОНХ-ийн сайдын 2014 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн А-03 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчинд нэлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-д заасны дагуу тус тусынхаа үүргийг гүйцэтгэнэ.
- 4.3. Гэрээний зүйлтэй холбоотой маргаантай асуудал гарах аваас хоёр тал хамтарсан протокол үйлдэн албажуулж, зөвшилцлийн замаар шийдвэрлэхийг хичээнэ.
- 4.4. Зөвшилцөн шийдвэрлэж чадаагүй нөхцөлд хуулийн байгууллагад хандана.

### ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

#### Захиалагчийг төлөөлж:


“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ”  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Хаяг: Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, 13-р хороолол /14230/, Нарны зам-62, Юнион Бюлдинг, Б блок, 11 давхар  
Утас: 7777-7727  
Цахим хаяг: [info@ttz.mn](mailto:info@ttz.mn)  
[environment@ttz.mn](mailto:environment@ttz.mn)

#### Гүйцэтгэгчийг төлөөлж:

“ЭН ЭС И КОНСАЛТИНГ” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



..... тоот гэрээний хавсралт

## “ЭН ЭС И КОНСАЛТИНГ” ХХК-ИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ХУВИАРЬ

№	Гүйцэтгэх ажил	1-р долоо хоног	2-р долоо хоног	3-р долоо хоног	4-р долоо хоног	5-р долоо хоног	6-р долоо хоног	7-р долоо хоног	8-р долоо хоног
1	Төсөл хэрэгжих талбайд очиж байгаль орчны суурь судалгаа, шинжилгээ хийж хөрс, ус, ургамал, агаараас дээж авч, амьтны тархалт нүүдлийн судалгаа хийх								
2	Төслийн талбайгаас авсан дээжинд итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэх								
3	Төсөл хэрэгжих газрын суурь мэдээллийг цуглуулж байгаль орчны өнөөгийн төлөв байдалд үнэлэлт дүгнэлт өгөх								
4	Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлон тайланд тусгах								
5	Төслийн байгаль орчинд шууд болон шууд бус нөлөөллийн бүсийг тогтоон судалгаа хийх								
6	БОАЖЯ-наас ерөнхий үнэлгээний дүгнэлт авах /БОАЖЯ хуулийн хутацаанд шийдвэрлэн гаргана/								
7	Төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлох								
8	Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн тооцоолох /холбогдох аргачлалаар нь/								
9	Төслийн усан хангамж, ус ашиглалт, хаягдлын тооцоог гаргах								
10	Төслөөс байгаль орчинд үзүүлж буй экологи эдийн засгийн үнэлгээг тооцох								
11	Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмжийг боловсруулах								
12	Хог хаягдлын менежмент төлөвлөгөө боловсруулах								
13	Төслийн хүрээнд эрслийн үнэлгээг тооцоолох								
14	Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах								
15	Орчны хяналт шинжилгээг хийх байршил, давтамжийг тодорхойлох								
16	Багийн иргэдийн нийтийн хурлаар тайланг танилцуулан санал авах (хамаарах хот, дүүрэг, аймаг, сүм тус бүрт)								
17	БОАЖЯ-ны шинжээчид БОННУ-ны тайланг хүргүүлж шүүмж авч, шүүмжийн дагуу засварлан дахин хүргүүлиэ.								
18	БОАЖЯ-ны хурлаар тайланг хэлэлцүүлж батлуулна. /БОАЖЯ-с төлөвлөгөөт хурлын товын дагуу орно/								

Жич: Дээрх ажлыг гүйцэтгэхдээ байгаль орчны бүрдэл бүрээр мэргэшсэн судлаачид, мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор, шинжлэх ухааны судалгааны аргазүй, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, “Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний аргачлал” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-ын дагуу гүйцэтгэнэ.



МОНГОЛ УЛС  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН  
НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИХ ЭРХИЙН

## ГЭРЧИЛГЭЭ

Дугаар: 0210019  
“ЭН ЭС И КОНСАЛТИНГ” ХХК

РЕГИСТРИЙН ДУГААР: 6601375

/Аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаар/

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 5., “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.1. дэх хэсэг, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 4.2., Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 01 дугаар сарын 29-ны өдрийн А/28. дугаар тушаалыг тус тус үндэслэн дараах чиглэлүүдээр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийн гэрчилгээг турван жилийн хугацаагаар олгов.

Үнд:

УУЛ УУРХАЙ

ДЭД БҮТЭЦ

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ

ҮЙЛЧИЛГЭЭ

БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Д.САРАНГЭРЭЛ

2021 оны 01 сарын 29-ны өдөр



МОНГОЛ УЛС  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭ

000209085

2020.08.04

9011820268

/Бүртгэсэн он, сар, өдөр /

/Хувийн хэргийн дугаар /

6601375

/Реестрийн дугаар /

Эн Эс И консалтинг

Хязгаарлагдмал хариуцлагатай  
компани

/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/Үүсэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

01

2020.07.28

/шийдвэрийн нэр /

/дугаар /

/он, сар, өдөр /

79110

Аялал жуулчлал

/Код /

/Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

3

60.00



/хугацаа /

/гишүүдийн тоо /

/хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгээр /

Улаанбаатар, Сонгинохайрхан, 27-р хороо, орчлон хороолол, хд 46, 59 тоот, Утас1: 99003459,  
Утас2: 91923776, Факс:

/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/



Улсын бүртгэлийн өрөнхий газар  
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн  
газар

/Бүртгэсэн байгууллагын нэр /



ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

## АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГЭРЧИЛГЭЭ

20<sup>22</sup>. оны 5 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 22/152

Улаанбаатар  
 хот

Улсын бүртгэлийн 9011820268 дугаар гэрчилгээтэй

"ЭН ЭС И КОНСАЛТИНГ" ХХК

Нь нууцад хамаарах үйл ажиллагаа гүйцэтгэхтэй холбогдуулан төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжид заасан холбогдох шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж баталгаажуулан

"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хэрэгжүүлж буй Богдхан төмөр зам төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ажлыг гүйцэтгэх тул

аюулгүй байдлын гэрчилгээ олгов.

Уг гэрчилгээ нь олгосон өдрөөс эхлэн ....хоёр..... жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.




№	Аюулгүй байдлын гэрчилгээний хугацааг сунгасан тухай тэмдэглэл	

**Санамж**

Гэрчилгээг засварлах, нэмж бичих, гэрчилгээг зөвшилгэлийг хуулбарлах, гэрчилгээг бусдад шилжүүлэх, ашиглуулахыг, гэрчилгээнд завгаагүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

БАТЛАВ  
“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-  
ИНГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.УДААНЖАРГАЛ

“БОГДХАН ТӨМӨР ЗАМ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН  
НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН БӨЛОВСРУУЛАХ  
СУДАЛГААНЫ АЖЛЫН АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 5 дугаар сарын  
30-ны өдөр

№ .....

Улаанбаатар  
хот

1	<b>Ажил гүйцэтгэх үндэслэл:</b>	<ul style="list-style-type: none"> <li>➤ “Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 254 дүгээр тогтоол;</li> <li>➤ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.4 дэх хэсэг;</li> <li>➤ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6, 7, 8 дугаар зүйлүүд;</li> <li>➤ Байгаль орчныг хамгаалах тухай хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актууд (усны тухай хууль, хог хаягдлын тухай хууль, амьтны тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам);</li> </ul>
2	<b>Хөрөнгө оруулалтын эх үүсвэр:</b>	“Тавантолгой төмөр зам” ХХК, гэрээний нөхцөлийн 1.2 -т заасан
3	<b>Захиалагч байгууллага:</b>	“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Байгаль орчин, орон нутгийн хэлтэс
4	<b>Байршил:</b>	Улаанбаатар хотын СХД-ийн 21, 32 дугаар хороо, Төв аймгийн Аргалант, Алтанбулаг, Баян, Сэргэлэн сумдын нутагт хэрэгжих 146.6 км –ын төмөр зам
5	<b>Төсөл хэрэгжүүлэх хугацаа:</b>	Эхлэх 2022 оны <u>06</u> дугаар сарын <u>05</u> -ны өдөр Дуусах 2022 оны <u>08</u> дугаар сарын <u>03</u> -ны өдөр хүртэл (эцсийн тайлан хүлээн авах).
6	<b>Гүйцэтгэх ажил, түүнд тавигдах ерөнхий</b>	<p>Богдхан төмөр зам төслийн төлөв байдлын тайланг дараах хүрээг хамруулан боловсруулна. Үүнд:</p> <p>a) Уг төслийн барилга угсралтын ажлын үе болон ашиглалтын</p>

		<p><b>шаардлагууд:</b></p> <p>үед шууд холбоотой дэд бүтэц, барилга байгууламжууд.</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Төмөр замын дээд болон доод бүтэц;</li> <li>➤ Эрчим хүчний шугам, сүлжээ;</li> <li>➤ Барилга, орон сууц (өртөө, зөрлөг);</li> <li>➤ Ажилчдын түр хотхон (кемпүүд);</li> <li>➤ Бетон зуурмагийн үйлдвэр;</li> <li>➤ Усан хангамжийн барилга байгууламж;</li> <li>➤ Цэвэрлэх байгууламж, хог хаягдал;</li> <li>➤ Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордууд;</li> <li>➤ Технологийн зам;</li> <li>➤ Шилэн кабель болон бусад барилга угсралтын талбай;</li> </ul> <p>б) Байгаль орчны төлөв байдлын тайлан болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээг дараах баримт бичгийн дагуу хийж гүйцэтгэх ба нэмэлтээр оруулах нарийвчилсан судалгаа хийнэ.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ “Аргачлал батлах тухай” Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-117 дугаар тушаал (хавсралт 1, 2)-ын дагуу хийж гүйцэтгэнэ;</li> <li>➤ Зэрлэг ан амьтны нүүдэл, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх судалгаа;</li> <li>➤ Бэлчээрийн мал аж ахуйн бэлчээр, усан хангамжийн (гар худаг, гүн өрмийн худаг) хуваагдлын судалгаа;</li> <li>➤ Зэрлэг болон мал, амьтны гарцыг тус трассын аль хэсэгт хэдэн ширхэг байршуулбал зохимжтой эсэх талаарх судалгаа;</li> <li>➤ Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд ашиглалтаас үүсэх хүн, байгальд үзүүлэх сөрөг нөлөөллийн судалгаа;</li> <li>➤ Түр замын ашиглалтаас үүсэх хүн, байгальд үзүүлэх сөрөг нөлөөллийн судалгаа;</li> <li>➤ Тухайн бүс нутгийн сайруудын их урсац болон бага урсацын тооцоо судалгааг нарийвчлан тооцож гаргах (5%, 10%, 33% болон 75%, 95%, 97%);</li> <li>➤ Бүлэг тус бүрийн ерөнхий болон нарийвчилсан газар зүйн зурагт оруулах;</li> </ul>
--	--	--

		<p>в) Бусад холбогдолтой ажлууд</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Гүйцэтгэгч нь ажлын даалгаврын дагуу ажлыг чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ;</li> <li>➤ Ажил гүйцэтгэх графикийг, гэрээний хавсралтаар оруулна;</li> <li>➤ Гүйцэтгэгч ажлын явцын тайланг үе шаттайгаар фото зургаар баталгаажуулан захиалагчийн төлөөлөлд тайлагнаж, бүлэг тус бүрт санал дүгнэлт авч ажиллана;</li> <li>➤ Ажлыг графикт хугацаанд уг төслийн байгаль орчны төлөв байдлын тайлан болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг бүрэн хийж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагаар батлуулж, актаар хүлээлгэн өгнө;</li> <li>➤ Байгаль орчны төлөв байдлын тайлан болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг (1 хувь, холбогдох илтгэлийн хамт электрон /файл word, pdf/ хэлбэрээр) захиалагч талд хүлээлгэн өгнө;</li> <li>➤ Байгалийн давагдашгүй хүчин зүйл (гамшиг, гал түймэр, үер)-ээс сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах ба хэрэв ямар нэг арга хэмжээ авалгүй гэнэтийн гамшигт өртвөл гүйцэтгэгч хариуцна;</li> <li>➤ Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангаж, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна;</li> <li>➤ Үнэлгээн дэх олон нийтийн оролцоог хангахдаа БОНХ-ийн сайдын 2014 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн А-03 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-д заасны дагуу тус тусынхаа үүргийг гүйцэтгэнэ;</li> </ul>
7	<b>Гүйцэтгэгч багт тавигдах шаардлага:</b>	<p>Гүйцэтгэгч нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагаас олгодог “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх” эрхийн дэд бүтэц, үйлчилгээ, уул уурхайн чиглэлийн тусгай зөвшөөрөлтэй, хуулийн этгээд байх;</p> <p>Гүйцэтгэгчийн судалгааны баг нь тухайн салбартаа мэргэшсэн экологич, гидрогеологич, биологич, газарзүйч, газар зүйн</p>

		<p>мэдээллийн систем, дэд бүтэц, төмөр замын инженер, мэргэжилтэнгүүд байх;</p> <p>Багийн ахлагч нь байгаль орчны чиглэлийн мэргэжилтэй, докторын зэрэгтэй 10-аас дээш жилийн ажлын туршлагатай байх, багийн гишүүд нь магистр ба түүнээс дээш зэрэгтэй 3-аас доошгүй жилийн ажлын туршлагатай байх;</p> <p>Багийн гишүүд нь монгол хэл дээр бичиг баримт боловсруулах, уулзалт хийх, харилцах, хамтран ажиллах чадвартай байх;</p>
8	<b>Захиалагчийн хяналт:</b>	<p>Ажлыг гүйцэтгэж эхлэхээс дуусах хүртэлх бүх үйл ажиллагаанд хяналт тавих;</p> <p>Ажлын явц, гүйцэтгэлийг хянах зориулалтаар 2 удаа хөндлөнгийн хяналт хийх зардлыг гүйцэтгэгч хариуцна.</p> <p>Хяналтын зардлыг нэгдсэн төсвийн дүнгээс 5 хүртэлх хувиар тооцно.</p>

Хавсралт-1 Богдхан төмөр зам төслийн трассын зураг.

Хавсралт -1

